


БАТЛАВ
“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.БАТСҮХ

2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

БАТЛАВ.
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 017 ДУГААР
АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА



Д.ДОРЖДЭРЭМ

2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

АТТ-20/117-114/30

Энэхүү гэрээг Барилгын тухай, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК, түүнийг төлөөлж Төслийн нэгжийн зохицуулагч С.СОД-ЭРДЭНЭ (цаашид “Захиалагч буюу “МТЗ” ТӨХК гэх);
Зэвсэгт хүчний 017 дугаар анги, түүнийг төлөөлж Ерөнхий инженер, хошууч Д.ЛХАГВАА (цаашид “Гүйцэтгэгч” гэх);
нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Гүйцэтгэх ажил, хугацаа, ажлын үнэ, хөлсний хэмжээг харилцан тохиролцож дараах нөхцлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг тохиролцсон хугацаанд хийж гүйцэтгэх, Захиалагч тал нь үнэ, ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг тодорхойлох, зохицуулахад оршино.

1.2 Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Тавантолгой Өртөөний барилга байгууламжийн нэр заасан ажил байх ба энэ нь ажлын үр дүн болно.

1.3 Гүйцэтгэгч талын гэрээний үүргийн хэрэгжилтэд Зэвсэгт хүчний бүтээн байгуулалт, дэмжлэгийн газар хяналт тавьж, удирдлага, арга, зүйгээр хангана.

1.4 Шинээр барих барилга байгууламжид дараах барилга угсралтын ажил багтана. Үүнд:

1.4.1 Өртөөний 40 айлын орон сууцны барилга (А-1);

1.4.2 Гадна цэвэр бохир, цэвэрлэх байгууламж.

1.5 Барилгын ажил гүйцэтгэхдээ үр ашигтай техник, технологийг сонгон ажиллах ба барилгын ажил гүйцэтгэх хугацааг богиносгож, барилгын чанарыг зураг төсөл, барилгын норм, дүрэмд заасан нормативт хэмжээнээс бууруулалгүй, төлөвлөсөн санхүүжилтэд багтаах, нөөц бололцоог ашиглах, хэмнэлтийн зарчмыг баримтлан ажиллана.

1.6 Барилгын ажлын зураг төсөл, ажлын тоо, хэмжээ, ажлын хуваарь, хугацаа, ажлын төсвийг Талууд харилцан тохиролцож, зөвшөөрсөн байна.

1.7 Гэрээний энэ зүйлд заасан бичиг баримт нь гэрээний хавсралт байх ба энэ нь Гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр, түүний салшгүй хэсэг байна. Үүнд:

Хавсралт-1: Магапдлал хийгдсэн зураг төсөл, ажлын зураг, ажлын тоо хэмжээ;

Хавсралт-2: Барилга угсралтын ажлын төсөв;

Хавсралт-3: Барилга угсралтын ажлын календарчилсан төлөвлөгөө;

Хавсралт-4: Тусгай зөвшөөрөл;

1.8 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээнд заагаагүй, урьдчилан төлөвлөх боломжгүй бусад асуудал, харилцаа үүссэн тохиолдолд Монгол Улсын Хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандарт, барилгын норм ба дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

1.9 Барилгын үйл ажиллагааг Барилгын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл, барилгын ажлын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

1.10 Энэхүү гэрээний хэрэгжилтэд Төслийн нэгж, Хяналт шалгалтын газар, Захиалагчийн инженер хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийг тайлагнана.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ нь 2020 оны 04 дугаар сарын 30-ний өдөр эхэлж, 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

2.2 Гүйцэтгэсэн барилгын ажлыг гэрээний Хавсралт 3-т заасан ажил гүйцэтгэх хуваарь, хугацааны дотор МТЗ-д тухай бүр хүлээлгэн өгнө.

2.3 Талууд гэрээний хугацааг харилцан тохиролцсоноор бичгээр үйлдэн сунгаж болно.

2.4 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол ийнхүү давагдашгүй хүчин зүйл үргэлжилсэн хугацаагаар ажил гүйцэтгэх хугацааг сунгасанд тооцно.

2.5 Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг өөрчлөх, хойшлуулах үндэслэл болохгүй.

2.6 Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид Иргэний хуульд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

3.1 Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажлын төсөвт өртөг нь Барилга угсралтын ажлын төсөвт заасан 3 525 167 687 төгрөг байна.

3.2 Гэрээний үнэ, төсөв, үнийн задаргааг хавсралт-2-д заасан ба үнэ, хөлсөнд цалин хөлс, үндсэн ажлын зардал, бараа, материал, техник, тээвэр, холбогдох бусад зардал бүгд багтсан болно.

3.3 Гэрээний үйлчлэх хугацаанд гэрээний үнэ өөрчлөгдөхгүй ба үнэ, төлбөрийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэнэ.

3.4 Гэрээний 3.1-д зааснаар гэрээний ажлын төлбөрийг дараах байдлаар шилжүүлнэ. Үүнд:

а) урьдчилгаа ажлын төлбөр- (гэрээн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор) – 40% ;

б) Гэрээний явцын төлбөрийг үе шатны ажлын гүйцэтгэлийн актын дагуу шилжүүлнэ.

Ингэхдээ урьдчилгаа төлбөрөөс хувь тэнцүүлэн суутгана ;

в) үлдэгдэл ажлын төлбөр-(ажил хүлээлцсэний дараа ажлын 5 хоногийн дотор)-15 %.

3.5 Захиалагч нь Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд Гүйцэтгэгчээс гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувийг уг хугацаа дуустал барьцаанд үлдээнэ.

3.6 Захиалагч ажлын үнэ, хөлсийг нэхэмжлэлийн дагуу Гүйцэтгэгчийн Төрийн сангийн 100200914401 харилцах дансанд шилжүүлгээр төлнө.

3.7 МТЗ шаардсан тухай бүрт Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын талаар зохих мэдээлэл, гэрээний хэрэгжилт, үе шатны ажлын тайланг хүргүүлэх ба эдгээр нь ажлын үнэ, хөлс төлөх үндэслэл болно.

3.8 Гүйцэтгэгч ажлыг шаардлага хангасан түвшинд гүйцэтгээгүй тохиолдолд Захиалагч нь зохих түвшинд хүргэх, шаардлага хангах хүртэл дараагийн ажлын хөлс, төлбөрийг саатуулах эрхтэй.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаас гадна зураг төсөл, төсөв, бусад зайлшгүй шаардлагатай баримт бичгийг Гүйцэтгэгчид шилжүүлэн өгөх, мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2. Барилгын ажлын санхүүжилтийг ажлын үе шат бүрт тухайн ажлыг баталгаажуулсны дараа төлнө.

4.3. Барилгын ажлын явц, түүний чанар, үр дүнд хяналт тавина.

4.4. Гүйцэтгэсэн барилгын ажилд гологдол, согог илэрвэл тухай бүрт арилгуулна.

4.5 Гүйцэтгэгч гэрээний үүргээ удаа дараа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол алданги ногдуулах, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх боломжгүй болсон тохиолдолд үнэ, хөлс төлөхөөс татгалзах, Хууль тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.

4.6 Гүйцэтгэгчийн ажил зохих норм, дүрэм, стандартын шаардлага хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах, дахин гүйцэтгэхийг шаардах, нөхөн гүйцээхэд гаргасан зардлыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх (төлөх ёстой төлбөрөөс суутган авах) эрхтэй.

4.7 Барилгын ажлыг хүлээн авснаас хойш хуульд зааснаар гомдлын шаардлага тавих эрхтэй.

4.8 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаас гадна зураг төсөл, бусад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг авах, ажил, үүргийг цаг хугацаанд нь мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, Захиалагчаас тавьсан шаардлагыг биелүүлэх, барилгын угсралтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.2 Гүйцэтгэгч нь гэрээний үнэ, хөлсийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах, ажил гүйцэтгэхтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл авах, тодорхой үндэслэлээр ажлын хугацаа сунгуулах эрхтэй.

5.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн баталсан зураг төсөл, норм ба дүрэм зөрчсөн, өөрчлөгдсөн, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн шаардлага хангаагүй гэрээний зүйлийг дахин үнэ төлбөргүй засч, залруулах, арилгах, өгсөн шаардлага, зааварчилгааг биелүүлэх үүрэгтэй.

5.4 Баталгаат хугацааны дотор чанарын доголдол гарвал өөрийн зардлаар засварлах үүрэгтэй.

- 5.5 Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдээр гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 5.6 Туслан гүйцэтгэгч ажиллуулсан тохиолдолд түүнтэй гэрээ байгуулах, түүний ажил, үүргийг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 5.7 Ажил гүйцэтгэх явцад өөрийн ажилтны ХАБЭА байдлыг бүрэн хариуцна.
- 5.8 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1 Гүйцэтгэгч нь барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй, хүлээлгэн өгөөгүй, хугацааг хэтрүүлсэн, чанарын доголдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги төлнө.
- 6.2. Захиалагчийн буруугаас барилга угсралтын ажлыг тасалдуулсан тохиолдолд холбогдох зардлыг Захиалагч хариуцна.
- 6.3 Алданги төлсөн нь Талуудыг гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх, учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл тухайлбал газар хөдлөлт , үер, гал түймэр, салхи, шуурга, халдварт өвчний тархалт, хорио цээр болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн байгууллагын шийдвэр, оролцоо зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас Захиалагч буюу Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол шаардлагатай хугацаагаар сунгаж болно.
- 7.3. Бараа, материал, түүхий эдийн хомсдол, үнийн өсөлт, үйлдвэрлэгч болон бараа нийлүүлэгчийн шийдвэр, хязгаарлалт нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй.

Найм. Маргаан шийдвэрлэх

- 8.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон Талуудын хооронд үүссэн санал, зөрөлдөөн маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.
- 8.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг асуудлыг харьяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 9.1. Барилгын ажил гүйцэтгэх явцад барилгын ажил, үнэ, хөлсөөс бусад нөхцөлд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь Талууд харилцан тохиролцож, зөвхөн бичгээр хийгдэж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Арав. Гэрээг цуцлах

- 10.1 Талууд харилцан тохиролцож хууль тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Арваннэг. Ажлын стандарт шаардлага, доголдол арилгах, баталгаа

11.1 Барилга байгууламж, төсөв, барилгын материал бүтээгдэхүүн нь Барилгын тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

11.2 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний хавсралтад заасан ажлын зураг төсөл, төсөв, техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу гүйцэтгэсэн, зохих стандартад нийцсэн ажлын үр дүнг хүлээлгэж өгнө.

11.3 Гүйцэтгэгч нь ажлын үр дүнд Иргэний хуульд заасны дагуу 3 жилийн баталгаа гаргаж өгнө.

11.4 Талууд ажлыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй, доголдол, эвдрэл гэмтэл гарсан, стандартын шаардлага, төрийн эрх бүхий байгууллагын чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон баталгаат хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг үнэ төлбөргүй засварлаж, доголдлыг арилгах үүрэгтэй.

Арванхоёр. Бусад зүйл

12.1 Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэн эсхүл хуульд заасан үндэслэлээр дуусгавар болно.

12.2 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглахыг хориглоно. Энэ заалт нь Гүйцэтгэгчийн төлөөлөгч, бүх ажилтан болон туслан гүйцэтгэгч нарт нэгэн адил хамаарна.

12.3 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Талууд шийдвэрлэнэ.

12.4 Гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн
Төслийн зохицуулагч

 С.Сод-эрдэнэ
Барилгын инженер


 О.Билгүүн


Харилцах утас: 99098562, 88117447

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороолол, 1 дүгээр хороо, UNION BUILDING, А блок, 7 дугаар давхар

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн
Ерөнхий инженер, хошууч

 Д.Лхагваа
Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн
Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан
бодогч, ахлах дэслэгч

 А.Амарбат
Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн
Хуулийн зөвлөх, дэд хурандаа

 Б.Балжинням

Харилцах утас: 7017-1348, 9209-0017

Хаяг: СХД, 38 дугаар хороо, өөрийн байр



Монголын
Барилгын
Үндэсний
Ассоциаци

956
"ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
017-Р АНГИ"-Д

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг,

5 дугаар хороо, Самбуугийн гудамж 24,

МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

Утас: + (976) 7011 1515

Утас: + (976) 7016 5055, + (976) 7018 5055

И-мэйл: info@mnca.mn, Вэб: www.mnca.mn

2020.03.25 № 20/02/126

Танай _____-ны № _____-т

Тодорхойлолт хүргүүлэх тухай

Танай компанийн барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн ажилбар шинээр авахаар 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн өргөдөл, материал нь 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн хурлаар хэлэлцэгдэж:

Шинээр:

БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, Хөргөх байгууламж тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт


БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил гэсэн ажлын төрлөөр "ДЭМЖИГДСЭН" болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ХУЛАН

000218

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2005.11.24
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9070001016
/Улсын бүртгэлийн дугаар/

5031109
/Регистрийн дугаар/

Зэвсэгтхүчний барилгын 017 дугаар анги

Төрийн байгууллага, албан газар, улсын
төсөөт үйлдвэрийн газар

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол
/Шийдвэрийн нэс/

220
/дугаар/

2005.11.24
он, сар, өдөр

454000
/код/

Зэвсэгт хүчний харьяа ангиудын их болон урсгал зэвсэг, амьсгалт
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Гуслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй
хугацаа

1

/гешүүдийн тоо/

500,000.0

/төрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Сонгинохайрхан, 18-р хороо, 1-р хороолол /Өнөр хороолол/, Өөрийн байр - 00, утас:1:531892, утас2:, факс:

/Хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар
Төрийн сан	Төгрөгийн	200914001



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
2	<p><i>Татвар төлөгчийн бүртгэл</i> <i>Компанийн</i></p> <p>8610 Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх /Гуравдугаар эрэглэл/ 2018.07.24-2021.7.24 эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.</p>	2007.05.	

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.


ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 017 ДУГААР АНГИ

**ТАВАНТОЛГОЙ ӨРТӨӨНИЙ АЖИЛЧДЫН 40 АЙЛЫН ОРОН СУУЦ, ГАДНА
БОХИР, ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТЫН ТӨСӨВ**

Төсөвт өртөг: 3 525 167 687 төгрөг

ТӨСӨВ ХИЙСЭН:

ТӨСӨВЧИН



Улаанбаатар хот 2020 он

**Тавантолгой-Зуунбаян чиглэлийн 416.6 км төмөр замын Өртөөний ажилчдын орон сууц,
гадна бохир, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын төсөв**

д/д	Зардлын нэр төрөл		40 айлын орон сууц	80 м3 цэвэрлэх байгууламж, гадна бохир	Нийт үнэ
1	Ажиллах хүчний зардал		434 044 069	50 237 618	484 281 687
2	Материал		1 381 200 472	472 266 808	1 853 467 280
3	Тээвэр		162 243 428	20 761 548	183 004 976
4	Механизм		33 709 218	5 131 317	38 840 535
	Дүн		2 011 197 187	548 397 291	2 559 594 478
5	Бусад нэмэгдэл зардал	69.90	155 004 651	17 940 723	172 945 374
	Дүн		2 166 201 838	566 338 014	2 732 539 852
6	Төсөвт ашиг	15%	324 930 276	84 950 702	409 880 978
	БУА-ын дүн		2 491 132 114	651 288 716	3 142 420 830
7	НӨАТ		249 113 211	65 128 872	314 242 083
8	Нормчлолын зардал		4 484 038	1 172 320	5 656 358
	Дүн		2 744 729 363	717 589 908	3 462 319 271
9	Захиалагчийн албаны зардал		-		-
10	Зураг төсөл, зохиогчийн хяналтын зардал		-		-
11	Магадлашгүй ажлын зардал		49822642	13025774	62 848 416
	Төсөвт өртгийн дүн		2 794 552 005	730 615 682	3 525 167 687